



Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Сургуулийн нэр: ИЗОУИС-ийн Үндэсний инженер технологийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Барилгын инженер

Хөтөлбөрийн индекс: D073202

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

V. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VI. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

VII. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

Хавсралт 1. Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн

Хавсралт 2. Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө

Товчилсон үг

ИЗОУИС	Их засаг олон улсын их сургууль
ҮИТС	Үндэсний инженер технологийн сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
CDIO	Conceiving-Designing-Implementing-Operating
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
АГҮБ	Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг
ЧБА	Чанарын баталгаажуулалтын алба
ДБСБ	Дээд боловсролын сургалтын байгууллага

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургууль /Монгол, Англи/	ИЗОУИС-ийн Үндэсний инженер технологийн сургууль National Engineering and Technology School of Ikh Zasag International University	
Хөтөлбөр /Монгол, Англи/	Барилгын инженер	Civil Engineering
Индекс	073202	
Шинжээчид	Р.Хишгээ	ШУТИС-ийн Барилга, архитектурын сургуулийн дэд профессор
	Б.Төрболд	ХААИС-ийн Инженер технологийн сургуулийн ахлах багш
	Д.Уранчимэг	Билгүүнбар компанийн ерөнхий инженер
Зохицуулагч	Ж.Тунгалаг	
Төлөвлөгөө	Огноо	Хийгдсэн байх ажлууд
	2021.11.11	Мэргэжилтэн шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг сонгож, ашиг сонирхлын зөрчилгүй болохыг тодруулах
	2021.11.23	Ажлын албаны захирал шинжээчийн багийг томиллох
	2021.11.24	Шинжээчтэй гэрээ байгуулан, өөрийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгч, урьдчилсан үнэлгээг эхлүүлэх
	2021.12.01	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2021.12.03	Мэргэжилтэн, шинжээчийн багийн ахлагч сургуульд очиж бэлтгэл хангуулах
	2021.12.06 2021.12.07	Шинжээчид танхимаар болон цахимаар ажиллах
	2021.12.14	Шинжээчид үнэлгээний тайлан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх

	2021.12.17	Шинжээчийн үнэлгээний тайланг сургуульд илгээж, санал авна
	2021.12.21	Сургууль санал, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2021.12.24	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд шинжээчийн үнэлгээний тайланг хэлэлцүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”, “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ыг баримтлав.	

II. БАРИЛГЫН ИНЖЕНЕР БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Ерөнхий чиглэл	07	Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт	Engineering, manufacturing and construction
Төрөлжсөн чиглэл	073	Архитектур ба барилга угсралт	Architecture and construction
Нарийвчилсан чиглэл	0732	Иргэний ба үйлдвэрлэлийн барилга байгууламж	Building and civil engineering

Хөтөлбөрийн нэр, индекс	Төгсөгчийн боловсролын зэрэг	МҮХ-ний түвшин	Суралцах хэлбэр	Суралцах хугацаа	Нийт багц цаг
Барилгын инженер 073202	Барилгын инженерийн бакалавр	VI	Өдөр	8 улирал	128 багц цаг
Civil Engineer	Bachelor of Civil Engineering	VI	fulltime	8 semesters	128 credit hour

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж						
Хөтөлбөрөөр анх элсэлт авч, сургалт эхлүүлсэн огноо						
Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа						
Хөтөлбөрийн өөрчлөлт (нэр, индекс, огноо)						
Хөтөлбөрийн хороогоор батлагдсан огноо:						
Багшлах бүрэлдэхүүний нийт тоо:						
Үүнээс	Үндсэн					
	Цагийн					
	Бусад					
Боловсролын зэрэг	Доктор					
	Магистр					
Албан тушаалын зэрэглэл	Профессор					
	Дэд профессор					
	Ахлах багш					
	Багш					
	Дагалдагч багш					
Ажлын туршлага	20-оос дээш жил					
	11-20					
	6-10 жил					
	5 хүртэлх жил					
Суралцагчдын нийт тоо		2020-2021	2019-2020	2018-2019	2017-2018	2016-2017

Үүнээс	4-р курс				
	3-р курс				
	2-р курс				
	1-р курс				
Төгсөгчдийн тоо					
Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын хаяг, утас, цахим хаяг					
Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбогдох хаяг, дугаар					
Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн давтамж:		Анх удаа			

III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Шалгуур 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Баримт нотолгоо

ШУТИС-ийн болон Казакстан, ОХУ-ын Барилгын инженер хөтөлбөртэй харьцуулсан судалгаа хийж хөтөлбөрийн агуулга, сургалтын төлөвлөгөөг боловсруулсан.

Хөтөлбөр нь оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг судлах зорилгоор Үндэсний инженер технологийн сургууль (УИТС) 2018-2019 оны хичээлийн жилд “Барилгын инженерийн хөтөлбөрт оролцогч, сонирхогч талуудын судалгаа”-г авсан байна.

Энэ хөтөлбөрөөр 4 удаагийн төгсөлт хийж, нийт 131 оюутан төгсгөснөөс 85% нь мэргэжлээрээ ажиллаж байгаа нь энэ хөтөлбөр барилгын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, эрэлт хэрэгцээтэй болохыг харуулж байна. Сүүлийн 5 жилд 196 шинэ элсэгч элсүүлсэн.

Төгсөлтийн шалгалтын комисст барилгын салбарын 1-2 мэргэжилтнийг урьж оролцуулан төгсөгчийн мэдлэг, чадварыг ажил олгогчдоор үнэлүүлэн, санал бодлыг авдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Үр дүнд суурилсан боловсролын чиг хандлага CDIO-г хөтөлбөрт баримталсан, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлоход хэрэглэсэн байна.

2018-2019 оны хичээлийн жилд авсан “Барилгын инженерийн хөтөлбөрт оролцогч, сонирхогч талуудын судалгаа”-нд оюутан, багшаас авсан асуулга нь багшийн заах арга зүй, сургалтын хөтөлбөрийн үр өгөөж, сургалтын орчин бүрдүүлэлттэй холбоотой сэтгэл ханамжийн түвшинг тогтооход чиглэсэн бол төгсөгч, ажил олгогчоос асуусан асуулгууд нь илүүтэй хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн байна.

Сул тал: Дээрх судалгааг хийсэн зорилго нь хөтөлбөрийг сайжруулах гэсэн боловч энэ судалгааны үр дүнг хөтөлбөрт хэрхэн тусгасан талаарх материал байхгүй байна. Дээрх судалгаа авснаас хойш 2 жил өнгөрсөн боловч дахин судалгаа аваагүй.

Дүгнэлт: 1.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Баримт нотолгоо:

Барилгын инженер технологийн мэдлэгийг системтэйгээр эзэмшсэн, манлайлах болон өрсөлдөх чадвартай, инженерийн болон нийгмийн ёс зүйтэй мэргэжилтэн бэлтгэхээр хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлсон.

Хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүн нь Их Засаг олон улсын их сургууль (ИЗОУИС)-ийн эрхэм зорилго, хөгжлийн мастер төлөвлөгөөнд нийцсэн. Сургалтын хөтөлбөр нь БШУЯ-наас хэрэгжүүлж буй Үр дүнд суурилсан боловсролын чиг хандлагатай уялдсан.

Ажил олгогчидтой хийсэн уулзалт дээр ИЗОУИС-ийн төгсөгчдийн гол давуу талыг тэдний харилцааны ур чадвар, хандлага төлөвшил, тууштай байдлаар тодорхойлж, энэ нь ажилд авах гол үндэслэл болдог тухай ярьсан.

Барилгын инженер хөтөлбөрийн суралцахуйн 18 үр дүнгийн 6 нь суралцагчийн хандлагад чиглэсэн үр дүнгүүд байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу болон сул тал: Хөтөлбөрийн гол онцлогийг хөтөлбөр хэрэгжүүлэгчид “Цогц боловсрол” хөтөлбөртэй уялдуулан тайлбарласан. Энэ нэмэлт сургалтын хөтөлбөр нь төгсөгчийн хүмүүжил, төлөвшилд чиглэдэг, төгсөгчид давуу тал бий болгоход гол үүрэгтэй байгаа хөтөлбөр хэрэгжүүлэгч, оролцогч талууд илэрхийлж байгаа ч сургалтын төлөвлөгөөнд албан ёсоор энэ хөтөлбөрт цаг хуваарилсан, үнэлгээ өгч дипломд бичигдэж албажсан зүйл одоогоор байхгүй байна. Зөвхөн төгсөгчийн тодорхойлолтод энэ тухай бичдэг юм байна.

Дүгнэлт: 1.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

Барилгын инженер хөтөлбөрийг анх 2014 онд баталснаас хойш 2018-2019, 2019-2020 оны хичээлийн жилүүдэд шинэчилсэн. 2018-2019 оын шинэчилэлээр БШУЯ-ны А/174 тоот тушаалаар баталсан Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагад нийцүүлсэн бол 2019-2020 оны өөрчлөлтөөр багц цагийн хуваарилалт, агуулгад өөрчлөлт оруулж хичээлүүдийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан.

Шинжээчийн үнэлгээ:

Сул тал: Сургалтын хөтөлбөрийн баримт бичигт заасан хөтөлбөрийн суралцахуйн үр дүн нь хичээлүүдийн хөтөлбөрт заасан хичээлээр олгох мэдлэг, ур чадвар, хандлагын жагсаалтаас зөрүүтэй байна. Мөн хөтөлбөрийн суралцахуйн үр дүн ба хичээлийн суралцахуйн үр дүнгийн хамаарлыг харуулсан матрицтай хичээлийн хөтөлбөрт бичсэн үр дүнгүүд таарахгүй зөрүүтэй байна.

Барилгын инженерийн бакалаврын хөтөлбөрт зайлшгүй судлах шаардлагатай Харимхайн ба налархайн онол, Байгууламжийн динамик ба тогтвор, Байгууламжийн сорил, шинжилгээ хичээлүүд сургалтын төлөвлөгөөнд байхгүй.

Хичээлүүдийн уялдаа холбоог харуулсан бүдүүвч ойлгомжгүй. Хичээлүүдийн уялдаа, залгамж хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг бий болгоход их чухал болохыг хангалттай ойлгоогүй. Жишээ нь Мэргэжлийн удиртгал хичээлийн бие даалтаар амины орон сууцны барилгын макет хийхээр төлөвлөсөн. Архитектур-1 хичээлээр амины орон сууцны төлөвлөлтийг үзэж энэ сэдвээр бие даалт хийхээр төлөвлөсөн тул Мэргэжлийн удиртгал хичээлийн өмнөх холбоо Архитектур-1 хичээл байвал зохистой байхад Математик, Физик хичээлүүдийг судалсан байхаар төлөвлөсөн байна.

Хичээлийн үнэлгээг хичээлийн хөтөлбөрт 2 ялгаатай байдлаар төлөвлөсөн. Үүнд: (1) явцын 70 оноо+улирлын эцсийн шалгалт 30 оноо, (2) нийт 100 оноогоор үнэлэхэд явцын шалгалт авч бие даалт, ирц, идэвхийн оноогоор үнэлээд улирлын эцэст ямар нэг шалгалт байхгүй байхаар төлөвлөсөн нь хөтөлбөрийн 2.9-д заасан улирлын эцсийн шалгалттай байхтай зөрчилдөж байна.

Хичээлийн хөтөлбөрийн төлөвлөлт, олгохоор зорьж буй мэдлэг, чадвар, хандлагыг нягтлах, хоорондын уялдаанд анхаарч засах шаардлагатай. Хичээл тус бүрийн үр дүн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг бий болгоно гэдгийг анхаарах хэрэгтэй.

Дүгнэлт: 1.3 шаардлагыг хэсэгчилэн хангасан байна.

ШАЛГУУР 1. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Шинжээчийн үнэлгээ: Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин хангалттай сайн, оролцогч талуудын эрэлт хэрэгцээг судлан хөтөлбөрийг сайжруулах оролдлого хийгдэж байгаа ч хөтөлбөрийн төлөвлөлт хичээлийн түвшинд хангалтгүй байна.

Шинжээчийн дүгнэлт: Хөтөлбөрийн төлөвлөлт шалгуурыг хэсэгчилэн хангасан байна.

Шаардлага:

1. Сургалтын төлөвлөгөөнд хичээлүүдийг судлах дараалал, уялдааг хангах
2. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй уялдуулан хичээлийн хөтөлбөрүүдийн суралцахуйн үр дүнг засаж, сайжруулах
3. Харимхайн ба налархайн онол, Байгууламжийн динамик ба тогтвор, Байгууламжийн сорил, шинжилгээ хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд нэмж оруулах

Зөвлөмж:

1. Хичээлийн суралцахуйн үр дүнг зөв тодорхойлж, зөв хэмжиж байж хөтөлбөрийн үр дүнд хүрнэ гэдгийг анхаарч хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах

Шалгуур 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Баримт нотолгоо:

Барилгын инженер хөтөлбөр бүтэц, хэлбэрийн хувьд А/174 тоот Бакалаврын хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан. Ерөнхий суурь хичээл 33 багц цаг, мэргэжлийн суурь хичээл 28 багц цаг, мэргэжлийн хичээл 56 багц цаг, дадлага ба төгсөлтийн ажил 11 багц цаг, нийт 128

багц цаг судалдаг. Нийт 12 багц цагийн 5 хичээлийг сонгон судлахаар сургалтын төлөвлөгөөнд тусгасан боловч энэ 5 хичээл нь заавал судлах хичээл адил сонголтгүйгээр ордог.

Шинжээчийн үнэлгээ:

Сул тал: Хэдийгээр хөтөлбөр бүтэц, хэлбэрийн хувьд бакалаврын сургалтад тавьдаг шаардлагыг хангаж байгаа ч үр дүнд чиглэсэн байдал буюу хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хөтөлбөрийн боловсролын зорилгод чиглэсэн байдлаар сургалтын төлөвлөгөөнд хичээлийн уялдааг суулгах, агуулгыг гаргах, хичээл тус бүрийн суралцахуйн үр дүн юу байх, хэрхэн хөтөлбөрийн үр дүнд хувь нэмрээ оруулах, хичээлийн үр дүнг хэмжих, үнэлэх зэргийн талаарх төлөвлөлт дутагдалтай байгаа тул хөтөлбөрийг цаашид сайжруулах шаардлагатайг харуулж байна. Энэ тухай 1.3 хэсэгт мөн дурдсан.

Зарим хичээлийн агуулга бакалаврын түвшний оюутанд ахадсан байна. Жишээ нь: ВU1 225 Судалгааны ажлын арга зүй хичээлийн агуулга, ашиглаж буй ном нь магистрын түвшнийх байна. 200 кодтой мэргэжлийн суурь хичээл атлаа өмнөх холбоо нь мэргэжлийн хичээлүүд гэсэн ерөнхий нэртэйгээс гадна энэ хичээлийн агуулгыг ойлгохын тулд математик статистик, магадлалын онолын суурьтай байхаар байна. Мөн SPSS программ хангамжийг хэрэглэх тухай 2-3 цагийн хичээлд зааж байгаа нь учир дутагдалтай, зөвхөн энэ программ хангамжийн судалж хэрэглэхэд бүтэн хичээл байж болохоор байна. Их засаг их сургуулийн барилгын инженер хөтөлбөрийн боловсролын зорилго 1 ба 2-т зааснаар төгсөгч нь судлаач байх, шийдвэр гаргах түвшинд асуудал шийддэг байхтай холбоотой энэ хичээл нэмэгдэж орсон нь эргээд оюутанд дарамт болохоор байна.

Дүгнэлт: 2.1 шаардлагыг хэсэгчилэн хангасан байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Баримт нотолгоо:

Сургалтын хөтөлбөрт зааснаар сургалтын арга зүй нь оюутан төвтэй идэвхитэй сургалтын арга зүйд суурилсан. Багш нартай хийсэн уулзалт дээр багш нар CDIO арга зүйг баримтлан идэвхитэй сургалтын арга зүйг хэрэглэж байгаа тухай ярьсан. Багш нарын сургалтын арга зүйд үнэлгээ өгөх ажлыг ИЗОУИС-ийн Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг (АГҮБ) жил бүр хийдэг. Энэ үнэлгээний багийн үнэлгээний тайлантай танилцсан.

2018-2019, 2019-2020 онд хөтөлбөрт хийсэн өөрчлөлттэй холбоотойгоор 2019 онд 3 удаа багшийн заах арга зүйн чиглэлээр сургалт хийсэн байна.

Сургалтанд XCloud, Moodle системийг ашигладаг. Цахим сургалтыг ихэвчлэн Zoom Meeting, Google Meeting ашиглаж явуулдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: УТИС, барилгын инженерийн хөтөлбөрийн сургалтын орчинтой танилцах явцад хэд хэдэн хичээлийн явцтай танилцсан бөгөөд 10-тын системээр цөөн хүүхэдтэй хичээлүүд орж байсан. 10-тын систем нь багаар ажиллах чадварыг дээшлүүлэх зорилготой ба харилцан бие биесээ хүндэтгэх, сонсох, суралцах, хамтрах чадварыг төлөвшүүлдэг хэмээн багш, суралцагчид сэтгэл ханамжтай байдаг талаар ярьсан. Төгсөгчидтэй хийсэн уулзалт дээр багш нар оюутнуудтай тулж ажилладаг байдал нь хөтөлбөрийн давуу тал болох тухай төгсөгчид ярьсан.

АГҮБ жил бүр багшийн хичээлд сууж, хичээлийн хавтас, ашиглаж буй материал, заах арга зүйтэй танилцан онооны системээр үнэлдэг байна. Үнэлгээгээр багшийг урамшуулж, зэрэг ахиулдаг.

Сул тал: Материалын эсэргүүцлийн лабораторийг гадагш мэргэжлийн судалгааны

байгууллагад очиж хийдэг гэсэн боловч оюутнууд болон төгсөгчид хаана очиж ямар лабораторийн ажил хийсэн талаар тайлбарлаж чадахгүй байна.

Үр дүнд суурилсан боловсролын арга зүй, идэвхитэй сургалтын арга зүйг хэрэглэж байгаа гэсэн боловч үүнийг нотлох баримт хангалтгүй байна.

Дүгнэлт: 2.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

ИЗОУИС-ийн Барилгын инженерийн хөтөлбөрт суралцагчийг уламжлалт амаар шалгаж асуух замаар тухайн хичээлээр олж авсан мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлдэг. Оюутны тоо цөөн тул энэ арга нь илүү зохимжтой байх талтай.

Өөрийн үнэлгээний тайланд сүүлийн 3 жилийн байдлаар I-IV курс тус бүрээр суралцагчдын сурлагын амжилт, чанарыг гаргасан боловч дүн шинжилгээ, дүгнэлт хийгээгүй.

Шинжээчийн үнэлгээ:

Сул тал: УИТС дээр ажиллах үеэр зарим хичээлийн хавтасуудыг үзэж багшаас үнэлгээг хэрхэн хийж байгаатай танилцсан. Амаар авах шалгалтын асуултууд нь жагсаасан сэдвүүдээс бүрдэж байсан бөгөөд мэдлэг, чадвар, хандлагыг хэрхэн ялгаж үнэлэх нь тодорхойгүй байсан нь хичээлийн хөтөлбөрийг хангалттай төлөвлөхгүй байгаатай холбоотой гэж үзэж байна. Хичээлийн суралцахуйн үр дүнг үнэлэхэд үнэлгээний үйл явц хангалттай чиглэж чадахгүй байна. Ур чадварын үнэлгээг хэрэглэдэг гэсэн боловч энэ талаарх нотолгоо баримттай танилцаагүй.

Өвчтэй, чөлөөтэй оюутны оноог 0,5 оноогоор хасдаг байдал ойлгомжгүй байна. Энэ нь буруу гэж үзэж байна.

Дүгнэлт: 2.3 шаардлагыг хэсэгчилэн хангасан байна.

ШАЛГУУР 2. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хөтөлбөрийн боловсролын зорилгыг хичээл тус бүрээр олгох суралцахуйн үр дүнтэй холбосон төлөвлөлт хэрэгтэй. Хичээлийн үр дүнг хэмжих, үнэлэх талаар ахиц гаргах шаардлагатай. Лабораторийн хичээлүүдийн чанарт хяналт тавих шаардлагатай.

Шинжээчийн дүгнэлт: Барилгын инженер бакалаврын хөтөлбөр нь сургалтын үйл ажиллагаанд тавих шалгуурыг хэсэгчилэн хангасан байна.

Шаардлага:

1. Барилгын инженер хөтөлбөрийн боловсролын болон суралцахуйн зорилготой уялдуулан Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг сайжруулах, өмнөх болон дараах хичээлүүдийн агуулгатай сайтар уялдуулах.
2. Зарим хичээлийн агуулга магистрын түвшиний, мэргэжлийн суурь зарим хичээлүүдийн өмнөх холбоо мэргэжлийн хичээлүүд байгаа зэрэг алдааг засах
3. Хичээлийн суралцахуйн үр дүнг бодитоор хэмжихээр суралцагчийн үнэлгээг төлөвлөх
4. Байгууламжийн сорил, шинжилгээний лабораторийг мөн нэмж байгуулах, хичээлийн хөтөлбөрт оруулах шаардлагатай.

Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, НӨӨЦ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад

дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Баримт нотолгоо:

2012 онд ашиглалтанд орсон 600 оюутны хүчин чадалтай хичээлийн байр, 2400м² талбайтай 364 оюутны дотуур байр, багш нарын орон сууцтай. 24 цагаар ажиллах боломжтой номын сантай, 392м² талбайтай спорт заалтай. Багш нарын 5 өрөө, оюутнууд бие даан ажиллахад зориулан тохижуулсан 3 өрөө, вестибюлдтэй. Сургалтын орчинтой холбоотой сэтгэл ханамжийн судалгаа авдаг ч үр дүнд анализ хийн буцаад үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн ажлын тайлан, нотлох баримт хангалтгүй.

Барилгын материал, геодези, цахилгаан, 3D роботикийн болон компьютерийн 3 лабораторитой. Магадлан итгэмжлэгдсэн лаборатори байхгүй. Цаашид барилгын инженер хөтөлбөрийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Хөрсний механик болон Материалын эсэргүүцлийн лаборатори байгуулахыг зорьж байгаа. Сургалтын орчин, нөөцтэй холбоотой Сэтгэл ханамжийн судалгааг оюутнуудаас авдаг ч үр дүнд анализ хийн буцаад үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн ажлын тайлан баримт нотолгоо хангалтгүй.

Шинжээчийн үнэлгээ:

ИЗОУИС-ийн 2009-2019, 2020-2025 он хүртэлх мастер төлөвлөгөө, ИЗОУИС-ийн ҮИТС-ийн ажлын төлөвлөгөөнд хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөцөд чиглэсэн ажлууд тусгагдан тодорхой түвшинд гүйцэтгэлтэй байгаа боловч Барилгын инженер хөтөлбөрийн онцлогт нийцсэн дадлагын газар, лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн нөөц болон ашиглалт хангалтгүй байна.

Сургалт, судалгааны орчны зай талбай, анги танхим дахь суудлын тоо хангалттай хүрэлцээтэй. Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байгаа нь сайшаалтай. Цахим сургалтын төв, Цогц боловсролын төв байгуулсан, оюутны бие даан ажиллах өрөөг тохижуулсан нь цахим сургалтын хүртээмжид эерэгээр нөлөөлсөн байна. Харин Барилгын инженерийн хөтөлбөрт зайлшгүй шаардлагатай лаборатори, тухайлбал Материалын эсэргүүцэл, Байгуулалмжийн сорил шинжилгээний лабораториуд байхгүй байгаа нь сургалтын чанар, төгсөгчдийн ур чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй

Дүгнэлт: 3.1 шаардлагыг хэсэгчлэн хангасан гэж дүгнэлээ.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Баримт нотолгоо:

Үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалд тулгуурлан Барилгын инженерийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөгөө шинэчилж боловсруулан хэрэгжүүлэхийг зорьж байгаа бөгөөд багш нар нь биет үзүүлэн, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэж ашиглан сургалтаа явуулах эрмэлзлэлтэй. Номын санд номын баяжилтыг тогтмол хийдэг. Номын сан, сургалтын хэрэглэгдэхүүнтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг оюутнуудаас авдаг боловч үр дүнд анализ хийн цаашдын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн баримт нотолгоо хангалтгүй.

Xcloud, Moodle, Zoom meeting, Google meet зэргийг ашиглан цахим сургалт явуулж буйгаа танилцуулсан. Компьютерийн лабораториудад Auto CAD, REVIT, LIRA, SPSS программудыг суулган сургалтын хэрэгцээнд ашиглаж байгаа нь хүрэлцээтэй боловч Revit, SPSS зэрэг программууд сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж буй эсэх нь тодорхойгүй /оюутан, төгсөгчидтэй хийсэн уулзалтаар хүүхдүүд программын нэр, зориулалт, тус программын

орчинд хэрхэн ажилладаг тухай санахгүй байв/.

Шинжээчийн үнэлгээ: Компьютерийн 3 лабораторийн 75 компьютерт барилгын зураг төслийн AutoCad, Revit, барилгын тооцооны Lira, судалгааны ажлын үр дүн боловсруулах SPSS зэрэг программ хангамжуудыг суулган сургалтын хэрэгцээнд ашиглаж байгаа нь хүрэлцээтэй байна. Мөн цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан багш нар хичээлийн материалуудыг цахимжуулан Moodle системд байршуулсан ба Сургалтын албанаас цахим хичээлд хяналт тавин бүртгэл тооцоог хийснээр цахим сургалт тасралтгүй явагдах нөхцөл бүрдсэн байна.

Лабораторийн хичээлд ашигладаг бодис, түүхий эд материалуудын хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, сургалтын шаардлага хангасан лабораторийн ажлын заавар боловсруулж нийтийн хүртээл болгох, лабораторийн орчинд ажиллах хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатай.

Барилгын инженер хөтөлбөрийн оюутнууд төгсөлтийн ажлаа гүйцэтгэхдээ барилгын төсвийн Estimator программыг ашиглаж байгаа тул тус программ хангамжаар программ хангамжийн нөөцөө нэмэгдүүлэх шаардлагатай.

Дүгнэлт: 3.2 шаардлагыг бүрэн хангасан гэж үзлээ.

3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Баримт нотолгоо:

ИЗОУИС-ийн ҮИТС нь жил бүр шаардлагатай ном, сурах бичиг, норм дүрэм, сэтгүүлийн судалгааг хийж номын сандаа баяжилт хийдэг. Хичээлийн байр болон оюутны байранд 1200 орчим номын фондтой номын сангууд ажилладаг. Тус номын сангууд ушигчдын ая тухтай байх орчин нөхцөлийг хангасан тохижилттой бөгөөд өдөрт заалаар 80 – 150 уншигчдад үйлчилж, 200 – 300 номыг гэрээр олгодог. Электрон номын сандаа 580 орчим номын фондтой.

Номын сангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой Оюутны номын сангийн зөвлөл ажилладаг. ҮИТС-ийн оюутнууд дээрх номын сангаас гадна ИЗОУИС-ийн бусад харьяа сургуулийн номын сангуудаар үйлчлүүлэх боломжтой. Ном, сурах бичиг, гарын авлага худалдан авах санхүүгийн төсөв жил бүр өсөн нэмэгдэж байгаа.

Номын санд инженерийн чиглэлийн 1262 ном, сурах бичиг байгаагийн 721 нь барилгын инженерийн хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлд ашиглагддаг.

Шинжээчийн үнэлгээ:

Номын санд сүүлийн 5 жилд тасралтгүй ном сурах бичгийн баяжилт хийсэн бөгөөд ном сурах бичиг, гарын авлага худалдан авах санхүүгийн төсөв жил бүр өсөн нэмэгдэж байгаа. Танхимаар болон гэрээр олгох ном сурах бичгийн фондыг хүрэлцэхүйцээр бүрдүүлсэн.

Номын сангийн үйл ажиллагаа тогтворжсон, орчин нөхцөл үйлчлүүлэгчийн тав тухыг хангасан байна.

Дүгнэлт: 3.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 3. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Сургалт, судалгааны орчны зай талбай, анги танхим дахь суудлын тоо хангалттай хүрэлцээтэй. Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байгаа нь сайшаалтай. Цахим сургалтын төв, Цогц боловсролын төв байгуулсан, оюутны бие даан ажиллах өрөөг тохижуулсан нь цахим сургалтын хүртээмжид эерэгээр нөлөөлсөн байна. Харин Барилгын инженерийн хөтөлбөрт зайлшгүй шаардлагатай лаборатори, тухайлбал Материалын эсэргүүцэл, Байгууламжийн сорил шинжилгээний лабораториуд байхгүй байгаа нь сургалтын чанар, төгсөгчдийн ур чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Мөн одоо ашиглаж буй барилгын материал, хөрсний механикийн

лабораториудын багаж тоног төхөөрөмж, хийх шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг тогтворжуулах шаардлагатай.

Компьютерийн 3 лабораторийн 75 компьютерт барилгын зураг төслийн AutoCad, Revit, барилгын тооцооны Lira, судалгааны ажлын үр дүн боловсруулах SPSS зэрэг программ хангамжуудыг суулган сургалтын хэрэгцээнд ашиглаж байгаа нь хүрэлцээтэй байна. Мөн цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан багш нар хичээлийн материалуудыг цахимжуулан Moodle системд байршуулсан ба Сургалтын албанаас цахим хичээлд хяналт тавин бүртгэл тооцоог хийснээр цахим сургалт тасралтгүй явагдах нөхцөл бүрдсэн байна.

Лабораторийн хичээлд ашигладаг бодис, түүхий эд материалуудын хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, сургалтын шаардлага хангасан лабораторийн ажлын заавар боловсруулж нийтийн хүртээл болгох, лабораторийн орчинд ажиллах хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатай.

Номын санд сүүлийн 5 жилд тасралтгүй ном сурах бичгийн баяжилт хийсэн бөгөөд ном сурах бичиг, гарын авлага худалдан авах санхүүгийн төсөв жил бүр өсөн нэмэгдэж байгаа. Танхимаар болон гэрээр олгох ном сурах бичгийн фондыг хүрэлцэхүйцээр бүрдүүлсэн. Номын сангийн үйл ажиллагаа тогтворжсон, орчин нөхцөл үйлчлүүлэгчийн тав тухыг хангасан байна.

Шинжээчийн дүгнэлт: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин нөөц шалгуурыг хэсэгчлэн хангасан байна.

Шаардлага:

1. Материалын эсэргүүцлийн, Байгууламжийн сорил шинжилгээний лаборатори, Барилгын процессын технологи, Барилга угсралтын технологи хичээлүүдийг заах дадлагын газруудыг байгуулах
2. Сургалтанд ашиглаж буй лицензтэй программ хангамжийн тоог нэмэгдүүлэх, барилгын төсвийн Estimator программыг лицензтэйгээр авч, сургалтанд ашиглах
3. Бүх лабораторийн ажлын зааврыг шинэчлэн боловсруулан хэвлэж, сургалтанд тогтмол ашиглаж хэвших

Зөвлөмж:

1. Жил бүр авдаг “Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц”-тэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд анализ хийн, үйл ажиллагаандаа системтэйгээр тусган хэрэгжүүлэх.
2. SPSS, Revit зэрэг программ хангамжууд сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж буй эсэхэд дүн шилгээ хийн үр дүнг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх.
3. Барилгын материал, Хөрсний механикийн лабораториудаа магадлан итгэмжлүүлэх
4. Гэрээт лаборатори болон байгууллагууд дээр лаборатори, практик сургалтууд явуулдаг гэж танилцуулсан боловч нотлох баримт хангалттай байгаагүй. Тиймээс цаашдаа гэрээт байгууллагууд дээр сургалт явуулахдаа үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх.

Шалгуур 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежмент, маркетингийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийн шинэчлэлт, хэрэгжилтийн явцад ИЗОУИС-ийн эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, Сургалт, инноваци эрхэлсэн проректор, Чанарын баталгаажуулалтын алба, Сургалтын нэгдсэн алба, Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг, Хөтөлбөрийн хороо хяналт тавин, үнэлгээ дүгнэлт өгч ажиллахаар зохион байгуулагдсан боловч хөтөлбөрийн удирдлагын түвшинд Барилгын инженер мэргэжилтэй боловсон хүчин одоогоор байхгүй.

Хөтөлбөрийн хороо, АГҮБ, албадын зүгээс Барилгын инженер хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавин үнэлгээ, дүгнэлт өгдөг боловч түүнийхээ хэрэгжилтэнд анхааран, ахиц дэвшил гарч буй эсэхэд шинжилгээ, дүгнэлт хийх үйл ажиллагаа зохион байгуулсан баримт нотолгоо хангалтгүй байна.

Хөтөлбөрийн багийн зүгээс ИЗОУИС-ийн стратеги төлөвлөгөө болон тухайн жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр ажлаа төлөвлөн улирал бүр гүйцэтгэлээ тайлагнадаг боловч хөтөлбөрийн чанарын үнэлгээ баталгаажуулалтыг өгөөжтэйгөөр зохион байгуулсан ажлын тайлан, нотолгоо баримт дутмаг.

Шинжээчийн үнэлгээ:

Хөтөлбөрийн удирдлагад барилгын инженерийн мэргэжилтэй боловсон хүчингүй байгаагаас хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилт, үнэлгээний чанарт сөрөг нөлөөтэй. Харин багш нарын хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ хөтөлбөрөө боловсруулсан, нэмэлт өөрчлөлт оруулж сайжруулсан байдлыг нэг заалт болгон оруулдаг нь мэргэжлийн суурь болон, мэргэжлийн хичээлийн хөтөлбөрийн шинэчлэлд түлхэц болдог.

Дүгнэлт: 4.1 шаардлагыг хэсэгчлэн хангасан байна.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

Монголын барилгын инженерүүдийн холбоо, Монголын барилгачдын холбоо, Барилга угсралтын болон зураг төслийн компаниуд гэх мэт төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, семинар зохион байгуулах, ШУТИС, ҮБХИС зэрэг сургуулиудтай харилцан туршлага солилцох, оюутан суралцагчидаа тэмцээн уралдаанд оролцуулах зэргээр хамтран ажилладаг. Одоогоор Барилгын инженер хөтөлбөрийн багш, суралцагч солилцооны ямар нэгэн хөтөлбөр хэрэгжүүлсэн тайлан, нотлох баримт байхгүй.

“Шидэт ном”, “1 оюутан 1кг” зэрэг нийгэмд чиглэсэн хүмүүнлэгийн ажлыг хөтөлбөрийн багш оюутнуудын зүгээс жил бүр хамтран зохион байгуулдаг.

Тус хөтөлбөрөөр төгсөгчид нь ИЗОУИС-ийн төгсөгчдийн холбооны үйл ажиллагаанд хамрагддаг. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багийн зүгээс төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулсан тайлан, баримт нотолгоо хангалтгүй.

Барилгын инженерүүдийн холбооноос тус хөтөлбөрт 141 ном, сурах бичиг хандивласан ба мэргэшсэн инженерийн сургалтанд багш нар 9 удаа хамрагдсан байна.

Шинжээчийн үнэлгээ:

ИЗОУИС нь Гадаад харилцааны бие даасан албатай, гадаадын 50 гаруй байгууллагатай хамтын ажиллагаатай, багш, оюутан солилцдог, бакалаврын 1+3, 2+2, магистрын 1+1 хамтарсан хөтөлбөр хэрэгжүлдэг боловч Барилгын инженер хөтөлбөрийн хувьд багш, оюутан солилцоо болон хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж байгаагүй. Барилгын инженерийн

хөтөлбөрийн багш нарын санаачлагаар оюутны дадлага хийх компанитай гэрээ байгуулан, төсөлт ажилд оролцдог. Хөтөлбөрийн багш оюутнууд хамтран нийгэмд чиглэсэн, хүмүүнлэгийн ажлыг хэд хэдэн удаа амжилттай зохион байгуулсан.

Сүүлийн 5 жилийн байдлаар жилд дунджаар 5 оюутан хамтран ажиллагч байгууллагын тэтгэлгээр суралцсан.

Дүгнэлт: 4.2 шаардлагыг хэсэгчлэн хангасан байна.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь ИЗОУИС-ийн нэгдсэн төсвөөс санхүүждэг бөгөөд хөтөлбөрийн нийт орлогийн 95%-ийг сургалтын төлбөр, 5%-ийг түрээс болон түр сургалтын орлого бүрүүлдэг. Нийт зардлын задаргааг авч үзвэл сургалттай холбоотой шууд зардалд 35%, шууд бус зардалд 25%, оюутны хөгжилд зориулсан зардалд 17%, багшийн хөгжилд зарцуулсан зардалд 17% -ийг тус тус эзэлж байна. Нэг оюутанд ноогдох өртөг зардлын тооцоог жил бүрээр нарийвчлан гаргасан бөгөөд сургалтын төлбөрийн 87% орчим нь буцаад хөтөлбөрт зарцуулагддаг байна.

Шинжээчийн үнэлгээ:

ИЗОУИС-ийн ҮИТС-ийн хувьд оюутны тооны өсөлттэй холбоотойгоор сургалттай холбоотой шууд зардал сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өссөн. Оюутны болон багшийн хөгжилд зарцуулсан зардлын хэмжээ нь нийт зардлын 34%-хүртэлх хэмжээг эзэл байгаа нь сайн үзүүлэлт юм. ИЗОУИС-ийн хэмжээгээр нэгдсэн төсөвтэй тул хөтөлбөрийн хувьд оюутны тоо цөөрсөн ч эрсдэлд ордоггүй.

Дүгнэлт: 4.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Баримт нотолгоо:

Телевиз, радиогоор сурталчилгааны мэдээлэл тогтмол түгээх, кино театрт мэдээлэл цацах, боловсролын үзэсгэлэн яармагт оролцож Барилгын инженер хөтөлбөрийн сурталчилгаа хийх, Нийслэлийн ЕБС-уудад танилцуулга хийх, ИЗОУИС-аас нийслэлийн ЕБС-ийн төгсөгчдийн дунд “Их сунгаа” боловсролын олимпиад зохион байгуулж тэргүүлсэн сурагчдад сургуульд суралцах эрхийн бичиг өгөх, 21 аймагт хөдөө орон нутгаас оюутан элсүүлэх комисс ажиллуулах зэргээр хөтөлбөрийн маркетингийн идэвхижүүлэлт хийдэг.

Шинжээчийн үнэлгээ:

Сургууль хөтөлбөрөө сурталчлах зорилгоор ЕБС-ийн сурагчдын дунд мэргэжил сурталчлах өдөрлөг, “Их сунгаа” олимпиад, сургуулийн танилцуулга уулзалт, Ажил олгогчидтой хамтарсан уулзалт зэргийг тогтмол зохион байгуулдаг. ИЗОУИС-ийн дэргэдэх Роял 98,9 FM радио, Роял HD телевиз зэрэг мэдээллийн хэрэгслээр хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг нийтэд тогтмол түгээдэг.

Дүгнэлт: 4.4 шаардлагыг бүрэн хангасан байна.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Баримт нотолгоо:

ИЗОУС-ийн дэргэдэх мэдээ мэдээллийн хэрэгсэл болон вэб хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээллээ түгээдэг. Мөн МИДСК, ХИДСХ-ны шугамаар зохион байгуулагддаг үзэсгэлэн, яармагт оролцох, 2010 оноос TV 8 телевизэд “Эрдмийн түлхүүр” нэртэй 7 хоног тутмын байнгын нэвтрүүлэг, 2009 оноос NTV, UBS, TV 9, 25-р суваг, ТВ 5, Боловсрол телевиз болон Монголын үндэсний радио, Зууны мэдээ, Өдрийн сонин, Үнэн, Үндэсний шуудан сонин, МОНЦАМЭ мэдээ зэрэг өдөр тутмын сонин хэвлэлд танилцуулгаа нийтлүүлэх зэргээр хөтөлбөрийн үйл олон нийтэд түгээдэг.

Шинжээчийн үнэлгээ: ИЗОУИС-ийн www.ikhzasag.edu.mn вэб хуудсанд тухайн хөтөлбөрийн мэдээ мэдээлэл нийтлэгддэг. ИЗОУИС-аас МҮОН-ийн радиотой хамтарсан “Их засаг сургуулиар сонин юу байна”, “Мөнх тэнгэрийн хүчин дор” зэрэг нэвтрүүлгүүдийг тогтмол давтамжтайгаар олон нийтэд хүргэдэг. Мөн Их засаг сургуулийн дэргэдэх Роял 98,9 FM радио, Роял HD телевизүүдээр ИЗОУИС-ийн мэдээ мэдээллийг нийтэд өргөнөөр сурталчилдаг. ИЗОУИС-ийн зүгээс мэдээ мэдээллээ нийтэд хүргэх үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулдаг боловч www.ikhzasag.edu.mn вэб дахь ҮИТС, Барилгын инженер хөтөлбөрийн танилцуулга мэдээлэл нь бодит хөтөлбөрийн хэрэгжилттэй нийцэлгүй, одоо суралцаж буй оюутнууд хөтөлбөрийн боловсролын зорилго зорилт, суралцахуйн үр дүнгийн талаар ойлголт мэдээлэл дутмаг байна.

Жил бүр Дүгнэлт: 4.5 шаардлагыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 4. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Хөтөлбөрийн удирдлагад барилгын инженерийн мэргэжилтэй боловсон хүчингүй байгаагаас хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилт, үнэлгээний чанарт сөрөг нөлөөтэй. Харин багш нарын хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ хөтөлбөрөө боловсруулсан, нэмэлт өөрчлөлт оруулж сайжруулсан байдлыг нэг заалт болгон оруулдаг нь мэргэжлийн суурь болон, мэргэжлийн хичээлийн хөтөлбөрийн шинэчлэлд түлхэц болдог.

Барилгын инженер хөтөлбөрийн хувьд багш, оюутан солилцоо болон хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж байгаагүй. Барилгын инженерийн хөтөлбөрийн багш нарын санаачлагаар оюутны дадлага хийх компанитай гэрээ байгуулан, төсөлт ажилд оролцдог. Хөтөлбөрийн багш оюутнууд хамтран нийгэмд чиглэсэн, хүмүүнлэгийн ажлыг хэд хэдэн удаа амжилттай зохион байгуулсан.

ИЗОУИС-ийн ҮИТС-ийн хувьд оюутны тооны өсөлттэй холбоотойгоор сургалттай холбоотой шууд зардал сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өссөн. ИЗОУИС-ийн хэмжээгээр нэгдсэн төсөвтэй тул хөтөлбөрийн хувьд оюутны тоо цөөрсөн ч эрсдэлд ордоггүй.

ИЗОУИС-ийн www.ikhzasag.edu.mn вэб хуудсанд тухайн хөтөлбөрийн мэдээ мэдээлэл нийтлэгддэг. ИЗОУИС-аас МҮОН-ийн радиотой хамтарсан “Их засаг сургуулиар сонин юу байна”, “Мөнх тэнгэрийн хүчин дор” зэрэг нэвтрүүлгүүдийг тогтмол давтамжтайгаар олон нийтэд хүргэдэг. Мөн Их засаг сургуулийн дэргэдэх Роял 98,9 FM радио, Роял HD телевизүүдээр ИЗОУИС-ийн мэдээ мэдээллийг нийтэд өргөнөөр сурталчилдаг. ИЗОУИС-ийн зүгээс мэдээ мэдээллээ нийтэд хүргэх үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулдаг боловч www.ikhzasag.edu.mn вэб дахь ҮИТС, Барилгын инженер хөтөлбөрийн танилцуулга мэдээлэл нь бодит хөтөлбөрийн хэрэгжилттэй нийцэлгүй, одоо суралцаж буй оюутнууд хөтөлбөрийн боловсролын зорилго зорилт, суралцахуйн үр дүнгийн талаар ойлголт мэдээлэл дутмаг байна.

Шинжээчийн дүгнэлт: Барилгын инженер бакалаврын хөтөлбөр нь хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтанд тавих шалгуурыг хэсэгчлэн хангасан байна.

Шаардлага:

1. Хөтөлбөрийн удирдлагын бүрэлдэхүүнд Барилгын инженер мэргэжилтэй мэргэжлийн хүн ажиллуулах
2. Хөтөлбөрийн хороо, Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг, Чанарын баталгаажуулалтын албаны гаргасан шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үнэлгээ дүгнэлт хийх, эргэн сайжруулах ажлыг зохион байгуулах

3. Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнд Барилгын инженер мэргэжилтэй хүнийг ажиллуулах (Хөтөлбөрийн хорооны дэргэд мэргэжлийн зөвлөл байгуулах).

Зөвлөмж:

1. Сургалтын алба, хөтөлбөрийн багийн CDIO стандарт, арга зүйд тулгуурлан хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх, үнэлгээний төлөвлөгөө хийх, үнэлэх чадамжийг дээшлүүлэх
2. Хөтөлбөрийн суралцагч, ажил олгогч, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг жил бүр хийх, судалгааны боловсруулалт ба дүн шинжилгээг сайжруулах, гарсан үр дүнгээр нь бодитой ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх
3. Багш, оюутан солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Шалгуур 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Баримт нотолгоо:

ЭЕШ-ийн шалгалтыг Математик-410 оноо, Физик-410 оноо, Монгол хэл-400 оноотой байхаар шалгуур чиглэлийг он зааж үзэхэд таарч байгаа нь дүрэм журмын биелэлт нотлох баримтаар харагдаж байна.

Суралцагчдын материалыг бүрдүүлэн төрийн сангийн буцалтгүй тусламжинд хамрагдуулж өгөх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Төрийн сангийн буцалтгүй тусламжийн дагуу 2015-2016 онд 211 оюутан, 2016-2017 онд 240 оюутан, 2017-2018 онд 332 оюутнууд тус тус хамрагдсан. Үүнээс барилгын инженерийн хөтөлбөрийн хувьд 2016-2017 онд 7 оюутан, 2017-2018 онд 8 оюутан 2018-2019 онд 8 оюутан төрийн сангийн буцалтгүй тусламжаар суралцсан байна.

Шинжээчийн үнэлгээ:

ҮИТС нь суралцагчдад амжилттай суралцаж, өөрийн хэрэгцээ, сонирхлын дагуу хөгжин төлөвшихөд нь дэмжих орчин нөхцлийг бүрдүүлж, тухайн хичээлийн жил бүр өөрийгөө хөгжүүлэх эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалт, хүмүүжил, соёл, олон нийтийн ажлын календарчилсан төлөвлөгөө гаргаж сургуулийн удирдлага, багш ажилчид, оюутны парламент, оюутны үйлчилгээний төв, оюутан үйлчилгээний хороотой хамтарч зохицуулалт, хэрэгжүүлэлтийн үйл ажиллагаа явуулдаг. Оюутны цогц чадварт суралцах, Оюутны хөгжлийг дэмжих журмыг хэрэгжүүлдэг ба социологийн судалгаа авч шийдвэрлэх үйл ажиллагаа явуулж шийдвэрлэсэн нөхцөлд хариу мэдэгдэл хийх зэргээр тогтвортой ажилладаг юм байна.

Дүгнэлт: 5.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Баримт нотолгоо:

Элсэгчдийг оюутан болгон төлөвшүүлэхийн тулд дараах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Шинээр элсэн орсон оюутнуудад шинэ орчинд дасан зохицох, сурах арга барил эзэмшүүлэх, оюутан болгон төлөвшүүлэх зорилгоор хичээлийн шинэ жилийн эхний хагаст угтах өдөрлөг, дүрэм журам танилцуулах, сургалтын нэгдсэн програм ашиглах X-CLOUD, MOODLE өдөрлөг зохион байгуулахаас гадна бүлэг удирдсан багш, захирал нар тогтмол яриа таниулга хийж, хурал зөвлөгөөн зохион байгуулдаг нь нотлох баримтаас үзвэл хангалттай сайн.

Оюутныг тал бүрийн авъяас чадварыг хөгжүүлэх зорилгоор олон үйл ажиллагаа явуулдаг нь мөн сургуулийн Facebook page болон нотлох баримтнаас үзэхэд хангалттай байна.

Шинжээчийн үнэлгээ:

Суралцагчид нь суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр сургуулиас тогтмол явуулдаг үйл ажиллагаанд нийтээрээ хамрагдаж оролцдог нь харагдаж байна.

Дүгнэлт: 5.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

Оюутны үүсгэл санаачлагын олон байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Тус сургуульд барилгын инженерийн хөтөлбөрийн оюутнуудын “Залуу инженер” клуб үйл ажиллагаа явуулж, санхүүжилт авсан нь баримтаар нотлогдож байна. Сургуулийн хэмжээнд оюутны үүсгэл санаачлагын байгууллагуудын үйл ажиллагаа тогтвортой, сайн ажиллаж байгаа нь сайшаалтай байгаа бөгөөд ҮИТС нь өөрийн оюутны байгууллагатай хамтран ажиллах талаар гэрээ хийж Ректорын тушаалаар төсөв батлан оюутанд чилэсэн үйлчилгээ хийх нөхцөлийг бүдүүлэн өгч Оюутны парламентын тэргүүнийг Удирдах зөвлөлд гишүүнээр авч оюутны дуу хоолой болгон албан ёсны орон тоонд тооцон, хамтран ажилласан байна. ИЗОУИС-ийн оюутны олон нийт, соёл хүмүүжлийн ажлын нэгдсэн графикайг жилээр төлөвлөн гаргаж, мөрдөж ажиллажээ.

Шинжээчийн үнэлгээ:

Оюутны гүйцэтгэх хороо, Оюутан үйлчилгээний төв, Оюутны ёс зүйн хороо ажиллаж, тэдгээрийн удирлага дор салбар сургуулиудын сайн дурын клубуудыг дэмжин ажиллуулж, оюутнуудад зориулсан уралдаан тэмцээн, эрдэм шинжилгээний хурал, тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн, санал хүсэлт сургуулийн танилцуулга, байршил бүтэц, санал хүсэлт, гомдол хүлээн авах, сэтгэл зүйн зөвлөгөө авах үйлчилгээ, автобусны билет захиалах, тэтгэлэг, угталтын 7 хоног сэтгэл ханамжийн судалгаа хийж, үр дүнд үнэлгээ гаргаж шийдвэрлэх гэх мэт үйл ажиллагааг хангалттай сайн явуулсан байна.

Дүгнэлт: 5.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Баримт нотолгоо:

ИЗ-ОУИС-д шилжин суралцах оюутан нь шилжин суралцах хүсэлтийг тус Сургалтын нэгдсэн албанд дүн болон ЭЕШ-ийн онооны хуудсын хамт өгч зөрүү хичээлийн дүнг тооцуулж, ИЗ-ОУИС-ийн I проректор Ж.Цэцэгмаа цохолт хийж, салбар сургуулийн захирал бүртгэж авч тухайн оюутны шилжилт хийгддэг юм байна.

Тухайн суралцагчийн хичээлийн зөрүү нь арваас илүү бол шилжүүлэн авахаас татгалзах бөгөөд суралцагчийн шалгалтын зөрүүг сургалтын нэгдсэн алба хариуцан барагдуулах арга хэмжээг авч салбар сургуулиас бүлэгт хуваарилан сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлдэг нь харагдаж байна.

Шинжээчийн үнэлгээ:

2018 онд шилжиж ирсэн 7 оюутны материалыг үзэхэд дүрэм журмын дагуу шилжин суралцсан байна. ЭЕШ-ын онооны бичиг баримтыг шалгахад 410-аас дээш оноотой оюутнууд байсан болно.

Дүгнэлт: 5.4 шаардлагыг бүрэн хангасан байна.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Баримт нотолгоо:

“Барилгын инженер” мэргэжлээр суралцагчид төгсөх курстээ Дипломын төслийн ажлыг бичиж бакалаврын дипломоо авдаг ба энэ мэргэжлээр төгсөгчдийн Дипломын төслийн хамгаалалтын дүн мэдээг 2017-2021 оны байдлаар нэгтгэн харуулсан хүснэгтээс үзвэл 131 төгсөгч диплом хамгаалснаас 72% нь А, 28% нь В үнэлгээтэй тус тус хамгаалжээ.

Төгсөгчийн дипломийн хавсралтанд суралцах хугацаанд судалсан хичээлүүдийн нэр, багц цаг, дүн, голч дүнг бичсэн нь тус хөтөлбөр нь хувь хүний өөр суралцсан оюутны гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан нь харагдаж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Суралцагчдад чиглэсэн үйлчилгээний бодлого, зохицуулалт: Суралцагчид өөрийгөө хөгжүүлэх эрэлт хэрэгцээндээ нийцсэн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, үйлчилгээний хүртээмж, чанарыг байнга сайжруулах тал дээр сайн ажиллаж ирсэн байна.

Дүгнэлт: 5.5 шаардлагыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 5. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Шинжээчийн дүгнэлт: Барилгын инженер бакалаврын хөтөлбөр нь суралцагчдад чиглэсэн үйлчилгээнд тавих шалгуурыг Шинжээчийн дүгнэлт: Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ нь суралцагчидын суралцах, төлөвших нөхцөлийг сайн бүрдүүлж байгаа тул тус шалгуурыг бүрэн хангасан гэж үзэж байна.

Шалгуур 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Баримт нотолгоо:

К. Болатгүл багш, Барилгын сантехникийн зөвлөх инженер, ДХАС хичээл, Г. Нарангэрэл багш, Мэргэшсэн инженер. Барилгын тооцооны программ, Долзодмаа багш, Барилгын угсралтын мэргэшсэн инженерийн сургалтын 10кр-тэй, Ш. Төрбат, Ph.D., Барилгын угсралтын зөвлөх инженер, Д.Очирбат Ph.D., Цагийн гэрээт багш, Барилгын эдийн засаг хичээлийг тус тус эрдмийн зэрэг цолтой, мэргэжлийн багш нараар заалгадаг юм байна. Эдгээр багш нарын хичээлүүдээс Барилгын тооцооны программ буюу ЛИРА-САПР программыг заадаг багшийн диплом, багшлах эрхийн үнэмлэх болон хичээлийн хөтөлбөртэй танилцлаа.

Шинжээчийн үнэлгээ:

Барилгын чиглэлийн эрдмийн зэрэг цолтой, мэргэжлийн багш нараар Барилгын инженерийн хөтөлбөрийн зорилго, зорилт болон онол дадлагыг хангахуйц хэмжээнд сургалтын арга зүйн мэргэжлийн шаардлагыг хангасан сургалт явуулдаг юм байна.

Дүгнэлт: 6.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Баримт нотолгоо:

Багшийн хөгжлийн бодлого нь багшийн хөгжлийн удирдлага, зохион байгуулалт, багшийн хөгжлийн үйл ажиллагааны чиглэл, багшийн мэргэшилд, судалгаа шинжилгээний чиг үүрэг, багшийн хөгжлийн дэд бүтцийг бий болгох, багшийн хөгжлийг санхүүгийн хувьд дэмжих гэсэн чиглэлээр батлагдсан. Багш ажилчдын хөгжлийг дэмжих 2014 оны журам, багшийн албан тушаалын зэрэглэл олгох 2012 оны журам, 2012 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг шалгахад багш, ажилтны хөгжил, үйл явцыг дэмжих зорилгоор батлан мөрддөг болох нь харагдлаа. Үүний хүрээнд багш бүр хичээлийн жилийн эхэнд төлөвлөгөө гарган “Багшийн хөгжлийн дэвтэр”-ээр дамжуулан үр дүнг хичээлийн жилийн эцэст дүгнэн ахиц дэвшлээ үнэлдэг систем тогтсон байна.

Багш, ажилтны ажлын нөхцөл, цалин хөлс, урамшуулал, дэмжлэг нь тэдний ажлын гүйцэтгэл, чанарт үндэслэсэн шударга, эрх тэгш, уян хатан хэрэгжих тогтолцоо бүрдсэн байх ба цаг үеийн шаардлагад тулгуурлан шинэчлэгддэг байна. Одоогоор 2017 оны 10 сарын 20 нд удирдах зөвлөлөөр баталсан их засаг олон улсын их сургуулийн багш нарын ажлын үр дүнг харгалзан олгох цалингийн журмыг мөрдөн ажиллажээ.

Ажлын гүйцэтгэлийг сургалт, судалгаа, бүтээлч ажил гэсэн 3 хэсэгт хуваан тооцдог, Жил бүр удирдах зөвлөлийн хурлаар “Их засаг” ОУИС-ийн “Багш нарын ажлын үр дүнг харгалзан олгох цалингийн журам”-ыг батлуулан ажилладаг. Энэхүү журамд ажилсан жилийн нэмэгдэл, ажлын гүйцэтгэлийн, албан тушаалын зэрэглэл, цол зэргийн нэмэгдэл, сургалт судалгаа, бүтээлч ажлын үр дүнг харгалзан урамшуулах талаар багтсан байна.

Багш ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх “Ажлын гүйцэтгэлийг үнэлэх баг” ажилладаг нь багш ажилчдын үнэлгээг жигд, хүртээмжтэй үнэлэх боломжийг олгосон. 2016-2021 оны хооронд ажлын гүйцэтгэлийн үнэлгээний багийн шалгалтаар хамгийн өндөр оноо авсан 70 багшийг гадаад мэргэжил дээшлүүлсэн, Бүтээлч ажлын цагийн нэмэгдэл нь сүүлийн 5 жилд давхардсан тоогоор 460 багшид 670 гаруй сая төгрөг нэмэлтээр олгосон. Цалингийн бүтэц нь 67% нь үндсэн цалин, 20% нь нэмэгдэл, 13% нь урамшуулал байна. Багш ажилчидтай уулзсан уулзалтаас багш нар сургуулийн орчин, цалин хөлс урамшуулал, удирдлагын талаар өндөр сэтгэгдэлтэй буюу сэтгэл ханамж сайтай, ажилдаа дуртай, идэвхи чармайлт сайтай болох нь доорх бичиг баримтуудаас ажиглагдлаа.

Түүнчилэн тус хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн Доктор Ph.D зэрэгтэй Ш.Төрбат, Д.Очирбат хоёр багш байгаа ба мэргэжлийн суурь болон мэрэгшүүлэх хичээлийг ордог найман багшаас үндсэн 6 багш нь магистрын зэрэг, багшлах эрхийн гэрчилгээтэй эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн ур чадвар эзэмшсэн багш бүрэлдэхүүнтэй юм байна. Мөн багш боловсон хүчин нь дараах байдлаар мэргэжлийн туршлага ур чадвараа дээшлүүлсэн багшийн нөөцтэй байна.

Шинжээчийн үнэлгээ:

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна гэсэн шаардагыг хангажээ гэж үзэв.

Сул тал: Хэдийгээр мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй боловч багш нарын олон улсын Impact Factor-тай сэтгүүлд хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллэг байхгүй байгаа дээр анхаарал хандуулаагүй нь ажиглагдлаа.

Дүгнэлт: 6.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Баримт нотолгоо:

Багш бүр эрдэмтэн судлаач байж, мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлэх, эрдэм судалгааны ажил тууривах үйлийг дэмжих зорилгоор ҮИТС-ийн багш нарын дунд “Их семинар” эрдэм шинжилгээний хурал жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг байна. Үүнээс шалгарсан багш нар “Багшийн хөгжил-XXI” болон гадны байгууллагуудад эрдэм шинжилгээний хуралд оролцож илтгэл хэлэлцүүлэх эрхтэй болохоос гадна “ИХ ЗАСАГ” сэтгүүлд илтгэл хэвлүүлж багш ажилчдыг дэмжих журмын дагуу Б цагийг тооцож, цалингийн нэмэгдэл олгодог болно.

Шинжээчийн үнэлгээ:

Багш нар нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй ажилладаг гэж дүгнэж байна.

Сул тал: Хэдийгээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, эмхтэл гаргаж байгаа ч дотоодын бусад их, дээд сургуулиудыг хамруулж, хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах тал дээр анхаарал хандуулаагүй нь ажиглагдлаа.

Дүгнэлт: 6.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Баримт нотолгоо:

Багш ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх “Ажлын гүйцэтгэлийг үнэлэх баг” ажилладаг нь багш ажилчдын үнэлгээг жигд, хүртээмжтэй үнэлэх боломжийг олгосон. 2016-2021 оны хооронд ажлын гүйцэтгэлийн үнэлгээний багийн шалгалтаар хамгийн өндөр оноо авсан 70 багшийг гадаад мэргэжил дээшлүүлсэн байгаа бөгөөд Бүтээлч ажлын цагийн нэмэгдэл нь сүүлийн 5 жилд давхардсан тоогоор 460 багшид 670 гаруй сая төгрөг нэмэлтээр олгосон. Цалингийн бүтэц нь 67% нь үндсэн цалин, 20% нь нэмэгдэл, 13% нь урамшуулал байна. Багш ажилчидтай уулзсан уулзалтаас багш нар сургуулийн орчин, цалин хөлс урамшуулал, удирдлагын талаар өндөр сэтгэгдэлтэй буюу сэтгэл ханамж сайтай, ажилдаа дуртай, идэвхи чармайлт сайтай болох нь ажиглагдлаа.

Шинжээчийн үнэлгээ: Багшийн нар нь сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээ тогтмол гүйцэтгэж ирсэн байна гэж дүгнэлээ.

Дүгнэлт: 6.4 шаардлагыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 6. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Багшийн үйл ажиллагаа нь Барилгын инженерийн бакалаврын хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэж ирсэн байна.

Шинжээчийн дүгнэлт: Барилгын инженер бакалаврын хөтөлбөр нь багшийн үйл ажиллагаанд тавих шалгуурыг бүрэн хангасан байна.

Зөвлөмж:

1. Багш нарыг мэргэшүүлэх сургалтанд хамрагдуулж, шаардлагатай кредит оноог авахуулж байхыг, мэргэшсэн инженер зэргээр чадвараа байнга ахиулахыг зөвлөж байна.

Шалгуур 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Баримт нотолгоо:

Шинжээчийн зүгээс тусгайлан 2016/2017 оны Metall бүтээц 1. 2 хичээлийн хөтөлбөрийг 2020/2021 оны Metall бүтээц 1.2 хичээлийн хөтөлбөртэй холбоотойгоор чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизм хэрхэн ажилласныг харьцуулан харав.

Дотоодын хяналтын үндсэн чиг үүргийг Их Засаг ОУИС-ийн АГҮБ, ЧБА гүйцэтгэж байгаа бөгөөд жил бүрийн хичээлийн эхэнд АГҮБ-ийн гишүүдийг ректорын тушаалаар томилон, сургуулиудаас ирж байгаа мэдээ, тайланд тулгуурлан тусгай удирдамжийн дагуу шалган, шалгагдсан сургуулиудыг авсан оноогоор нь байр эзлүүлэн дүгнэж илэрсэн доголдол дутагдлыг нь засаж арилгах талаар зөвлөмж чиглэл өгөх арга хэмжээ авдаг юм байна. ҮИТС сургууль 1 байрыг 3 удаа, 2-3 байрыг 3 удаа хүртсэн нь чанарын дотоод баталгаажуулалтын тайлангаас харагдаж байна.

Чанарын хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалтийг өөрийн санаачлагаар эрх бүхий, мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ, хийлгэсэн бөгөөд “Барилгын инженер”-ийн Барилгын яамны сайдын 2019 оны 209 тоот тушаалын дагуу 18 их дээд сургуулийн хөтөлбөрт үнэлгээ хийхэд “хангалттай сайн” гэсэн үнэлгээ авсан байна.

✓ Metall бүтээц-1 хичээлийн хөтөлбөрт дараах өөрчлөлтийг хийсэн байна.

Үүнд: 2020-2021 оны хөтөлбөрт Семинарын хичээлийн сэдэвт цувимал дамнурууны тооцоо, бүтээцлэлээс гадна ган хуудасны тооцоог хичээлийн агуулгад нэмж оруулжээ.

✓ 2020-2021 оны хичээлийн хөтөлбөрт мөн дараах өөрчлөлтийг хийсэн байна.

Үүнд: Лекцийн хичээлийн хөтөлбөрт Татангын төрлүүд гэж ерөнхий байсныг Тулаасыг фасонкод бэхлэх, татангыг баганатай холбох холбоосын тооцоо гэж сэдвийг тодорхой болгон өөрчилсөн байна.

Шинжээчийн үнэлгээ:

Хичээлийн хөтөлбөртэй холбоотойгоор ИЗОУИС-ийн чанарын үнэлгээний механизм нь барилгын инженерийн энэхүү хөтөлбөр дээр ажилладаг нь бүрэн харагдлаа гэж үзэв.

Дүгнэлт: 7.1 шаардлагыг бүрэн хангасан гэж үзэж байна.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Баримт нотолгоо:

Барилгын инженер-ийн хөтөлбөрт оролцогч, сонирхогч талуудын судалгаа 2018-2019, 2019-2020, 2020-2021 хичээлийн жилүүдэд авч нэгтгэн ном болгон хэвлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлжээ. Жишээ: ИЗОУИС –ийн ҮИТС-ийн оюутнуудаас 2019-2020 оны хичээлийн жилд [online /google form/](https://www.google.com/forms) хэлбэрээр 133 оюутнаас 114 оюутан хамрагдсан бөгөөд насны хувьд 16-18 насны оюутан 30.1%-ийг эзэлж байна. Хүйсийн харьцаа 85.5% нь эрэгтэй, 14.5% нь эмэгтэй оюутан байна. Судалгаанд багшийн заах арга хандлагын үнэлгээ, сургалтын үйл ажиллагаа, үнэнч байдал, сургалтаас авсан мэдлэг ур чадварын талаар, сургалтаас гадуурх үйл ажиллагаа гэсэн чиглэлээр судалгааг авч үр дүнг нэгтгэв. Судалгаагаар мэргэжлийн ном сурах бичиг, хичээлийн бус цагаар багш нартай хамт байдаг гэсэн асуулга дундаас доош үнэлгээтэй хариулт өгсөн нь анхаарч үзэх асуудлууд байгаа нь нэгдүгээрт цар тахалтай холбоотой хоёрдугаарт эдгээр асуудлуудын хүрээнд алдаа дутагдлаа засаж сайжруулах ажлуудыг зохион байгуулж номын сангийн баяжуулалт хийжээ. Мөн анги танхимуудад засвар үйлчилгээнүүдийг хийж сургалтын орчны тохижилтыг сайжруулсан байна.

Шинжээчийн үнэлгээ:

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажилладаг юм байна гэж дүгнэж байна.

Сул тал: Хэдийгээр төгсөгчдийн судалгааг хийж, ирсэн ч төгсөгчид ямар том бүтээн байгуулалт дээр ямар үүрэг рольтой амжилттай оролцож, шагнал урамшуулал авсан тухай судалгаандаа оруулахад анхаарал хандуулаагүй нь ажиглагдав.

Дүгнэлт: 7.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Шаардлагатай бол олгож буй эрдмийн зэрэг болон мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

Баримт нотолгоо:

ИЗ-ОУИС нь үйл ажиллагаандаа эрх бүхий мэргэжлийн байгууллага, гадаадын дээд боловсролын магадлан итгэмжлэлийн болон үнэлгээний байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж ирсэн байна Тухайлбал 2000 онд анхны, 2005 онд 2 дахь магадлан итгэмжлэлийг амжилттай хийлгэн 2012 онд ДБСБ-ын дээд боловсролын байгууллагын аттестатчилд орж амжилттай дүн үзүүлсэн байна. ДБСБ-ын магадлан итгэмжлэлд 2018 онд III дахь удаагаа магадлан итгэмжлэгджээ. 2012 оноос сургалтын хөтөлбөрүүдээ магадлан итгэмжлүүлэх ажлыг эхлүүлж, одоогийн байдлаар 8 хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн байна.

2014 болон 2017 онд Европын чанарын холбооны гишүүн байгууллага болох Их Британи, умард Ирландын нэгдсэн Вант улсын Үндэсний магадлан итгэмжлэх зөвлөлөөр итгэмжлүүлсэн байна. Тус сургууль нь 2008 онд Английн Лондон хотноо ВІD байгууллагын алтан категорийн Хаан” титэм, 2013 онд Парис хотноо зохион байгуулагдсан Дэлхийн Чанарын Баталгаажуулалтын шагналыг Platinum төрөлд хүртсэн байна.

2014 онд анх удаагаа Их Британийн Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл ВАС-аар магадлан итгэмжлэгдсэн бол II дахь удаагаа 2017 онд магадлан итгэмжлэгдсэн байна. Барилгын инженер хөтөлбөрийн хувьд:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 209 тоот тушаал, Барилгын хөгжлийн төвийн 2021 оны 11-р сарын 12-ны өдрийн 1/3007 тоот тушаалаар Барилгын салбарын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа их дээд сургуулиудын сургалтын чиглэл, хөтөлбөрт дүн шинжилгээ хийхэд Барилгын инженерийн хөтөлбөрийн үнэлгээг хийлгэсэн байна.
2. “Дээд боловсролын хөгжил”-ийн байгууллагаар 2019 оны 11-р сарын 20-ний өдөр үнэлгээ хийлгэж, тайлан болон хөтөлбөртөө тусгасан арга хэмжээ авсан байна.
3. Чингис хааны нэрэмжит ИЗ-ОУИС-ийн ректорын тушаалаар 2009-2019 оны мастер төлөвлөгөө 2010 оны 04 дүгээр сарын 9-ний өдрийн 1/174 тоот тушаалаар батлуулжээ.
4. ИЗ-ОУИС-ийн ТУЗ-ийн хурлын 2019 оны 11-р сарын 20-ний өдрийн дугаар 9 тоот тогтоолоор “Стратеги төлөвлөгөө”-г батласан байна.
5. ИЗ-ОУИС-ийн Ректорын 2019 оны 09-р сарын 23-ны өдрийн А/80 тоот тушаалаар ын ЧБА-ны ажиллах дүрэм-ийг баталсан байна. Үүнд: Нийтлэг үндэслэл, Чанарын баталгаажуулалтын албаны бүтэц бүрэлдэхүүн, Үйл ажиллагааны зорилг, чиг үүрэг, Чанарын баталгаажуулалтын албаны хяналт- шалгалтын хамрах хүрээ багтана.
6. ИЗ-ОУИС-ийн ЧБА-ын албыг байгуулж үйл ажиллагааны дүрмийг батлах тухай. Ректорын 2019 оны 09-р сарын 16-ны өдрийн А/146 тоот тушаалын 2 хавсралт
7. ИЗ-ОУИС-ийн ЧБА-наас 2021 онд хэвлэн гаргасан Чанарын баталгаажуулалтын гарын авлага
8. ИЗОУИС-ийн ЧБА-ны УИТС-ийн Сургалт, эрдэм шинжилгээний ажлын явцад “Барилгын инженер”-ийн хөтөлбөрийн жишээн дээр хийсэн дүн шинжилгээ /2021-11-19-ний өдөр/
9. АГҮБ-ийн шалгалтын үр дүнд ажил сайжруулах чиглэлээр цогцолбор, салбар сургуулиудад өгөх үүрэг даалгавар

10. ИЗОУИС-ийн АГҮБ-ИЙН Шалгалтын нэгдсэн дүн. /2019-10 сар, 2021-11-р сар/

11. ИЗОУИС-ийн Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг шалгах багийн үйл ажиллагааны 2019 оны 03 сарын 01 өдрийн тайлан.

Шинжээчийн үнэлгээ:

Мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн нь баримтуудаар хангалттай сайн харагдаж байна.

Дүгнэлт: 7.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 7. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын алба нь үүрэгт ажлаа хийдэг нь баримтуудаас харагдаж байна.

Шинжээчийн дүгнэлт: Барилгын инженер бакалаврын хөтөлбөр нь чанарын үнэлгээ, баталгаажилтанд тавих шалгуурыг бүрэн хангаж байна.

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан шаардлага (2)	Хэсэгчлэн хангасан шаардлага (1)	Хангаагүй шаардлага (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	1.1, 1.2	1.3	-	Бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	2.2	2.1, 2.3	-	Хэсэгчлэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3.2, 3.3	3.1	-	Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4.3, 4.4, 4.5	4.1, 4.2	-	Хэсэгчлэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5	-	-	Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	6.1, 6.2, 6.3, 6.4	-	-	Бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	7.1, 7.2, 7.3	-	-	Бүрэн хангасан
Нэгдсэн дүгнэлт		ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН			

Өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримт, уулзалт ярилцлагын тэмдэглэлд үндэслэн шинжээчийн баг “Барилгын инженер” бакалаврын хөтөлбөр нь БМИУЗ-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг хэсэгчлэн хангасан гэж дүгнэж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, чанарыг цаашид сайжруулах чиглэлээр дараах шаардлага/зөвлөмжийг өгч, шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохин бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

ШИНЖЭЭЧИЙН ШААРДЛАГА

1. Сургалтын төлөвлөгөөнд хичээлүүдийг судлах дараалал, уялдааг хангах
2. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй уялдуулан хичээлийн хөтөлбөрүүдийн суралцахуйн үр дүнг засаж, сайжруулах
3. Харимхайн ба налархайн онол, Байгууламжийн динамик ба тогтвор, Байгууламжийн сорил, шинжилгээ хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд нэмж оруулах
4. Барилгын инженер хөтөлбөрийн боловсролын болон суралцахуйн зорилготой уялдуулан Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг сайжруулах, өмнөх болон дараах хичээлүүдийн агуулгатай сайтар уялдуулах.
5. Зарим хичээлийн агуулга магистрын түвшиний, мэргэжлийн суурь зарим хичээлүүдийн өмнөх холбоо мэргэжлийн хичээлүүд байгаа зэрэг алдааг засах
6. Хичээлийн суралцахуйн үр дүнг бодитоор хэмжихээр суралцагчийн үнэлгээг төлөвлөх
7. Байгууламжийн сорил, шинжилгээний лабораторийг мөн нэмж байгуулах, хичээлийн хөтөлбөрт оруулах шаардлагатай.

8. Материалын эсэргүүцлийн, Байгууламжийн сорил шинжилгээний лаборатори, Барилгын процессын технологи, Барилга угсралтын технологи хичээлүүдийг заах дадлагын газруудыг байгуулах
9. Сургалтанд ашиглаж буй лицензтэй программ хангамжийн тоог нэмэгдүүлэх, барилгын төсвийн Estimator программыг лицензтэйгээр авч, сургалтанд ашиглах
10. Бүх лабораторийн ажлын зааврыг шинэчлэн боловсруулан хэвлэж, сургалтанд тогтмол ашиглаж хэвших
11. Хөтөлбөрийн удирдлагын бүрэлдэхүүнд Барилгын инженер мэргэжилтэй мэргэжлийн хүн ажиллуулах
12. Хөтөлбөрийн хороо, Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг, Чанарын баталгаажуулалтын албаны гаргасан шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үнэлгээ дүгнэлт хийх, эргэн сайжруулах ажлыг зохион байгуулах
13. Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнд Барилгын инженер мэргэжилтэй хүнийг ажиллуулах (Хөтөлбөрийн хорооны дэргэд мэргэжлийн зөвлөл байгуулах).

ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨМЖ

1. Хичээлийн суралцахуйн үр дүнг зөв тодорхойлж, зөв хэмжиж байж хөтөлбөрийн үр дүнд хүрнэ гэдгийг анхаарч хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах
2. Жил бүр авдаг “Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц”-тэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд анализ хийн, үйл ажиллагаандаа системтэйгээр тусган хэрэгжүүлэх.
3. SPSS, Revit зэрэг программ хангамжууд сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж буй эсэхэд дүн шилгээ хийн үр дүнг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх.
4. Барилгын материал, Хөрсний механикийн лабораториудаа магадлан итгэмжлүүлэх
5. Гэрээт лаборатори болон байгууллагууд дээр лаборатори, практик сургалтууд явуулдаг гэж танилцуулсан боловч нотлох баримт хангалттай байгаагүй. Тиймээс цаашдаа гэрээт байгууллагууд дээр сургалт явуулахдаа үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх.
6. Сургалтын алба, хөтөлбөрийн багийн CDIO стандарт, арга зүйд тулгуурлан хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх, үнэлгээний төлөвлөгөө хийх, үнэлэх чадамжийг дээшлүүлэх
7. Хөтөлбөрийн суралцагч, ажил олгогч, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг жил бүр хийх, судалгааны боловсруулалт ба дүн шинжилгээг сайжруулах, гарсан үр дүнгээр нь бодитой ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх
8. Багш, оюутан солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
9. Багш нарыг мэргэшүүлэх сургалтанд хамрагдуулж, шаардлагатай кредит оноог авахуулж байхыг, мэргэшсэн инженер зэргээр чадвараа байнга ахиулахыг зөвлөж байна.

IV. ХӨТӨЛБӨРИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАГААС ИРСЭН САНАЛ

/албан бичгийг оруулах/

V. МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ /МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ КОМИСС/-ИЙН ШИЙДВЭР:

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт:]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Шаардлага:

1.
2.

Зөвлөмж

1.
2.

VI. ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦОГЧДЫН НЭРС

I. Багш нарын нэрс

№	Багшийн нэр	Албан тушаал	Заадаг хичээл
1	Д.Чулуунбилэг	Захирал	
2	Б.Тунгалаг	Захирлын туслах	
3	Х.Гүнсэндулам	Декан	
4	Ш.Төрбат	Зөвлөх багш	
5	Ё.Гантогоо	ЦИХөтөлбөрийн удирдагч	Барилгын машин
6	Г.Наранбаатар	Багш	Судалгааны ажлын арга зүй
7	Д.Чинцэцэг	Багш	Эдийн засгийн онол
8	Д.Одгэрэл	Багш	Монгол хэл бичиг найруулга зүй
9	Т.Ганхүү	Багш	Эдийн засгийн онол
10	Б.Нацагдорж	Багш	Хүний хөгжил харилцааны ёс зүй
11	К.Болатгүл	БИХөтөлбөрийн удирдагч	Инженер мэргэжлийн оршил, Ус хангамж ариутгах татуурга, дулаан хангамж агаар сэлгэлт
12	Н.Ган-Эрдэнэ	МТХөтөлбөрийн удирдагч	Инженерийн математик-1,2
13	Т.Алтантуяа	Багш	Цогц боловсрол, Япон хэл
14	Б.Даваасүрэн	Багш	Дүрслэх геометр, Барилгын зураг зүй
15	Н.Долзодмаа	Багш	ИБУБА-1, 2 Барилгын процессын технологи, БҮЗБ-1,2 Барилга угсралтын технологи
16	Б.Индра	Багш	Сэтгэлгээний түүх соёл
17	Д.Солонго	Багш	Материалын эсэргүүцэл, Барилгын механик-1, 2, Онолын механик
18	Г.Нарангэрэл	Багш	Төмөр бетон бүтээц-1, 2, Барилгын материал, Барилгын тооцооны програм Хөрсний механик
19	Д.Батхишиг	Багш	Зураг төслийн автоматжуулалт Барилгын геодези, Барилгын эдийн засаг
20	Д.Шинэтулга	Хөтөлбөрийн удирдагч	Англи хэл
21	Г.Барсболд	Багш	Мэргэжлийн Англи хэл
22	Ганбат Оюунтуяа	Багш	Мэдээлэл технологи, мэдээллийн систем
23	С.Ганхуяг	Багш	Мэдээлэл технологи, мэдээллийн систем
24	Э.Тэлмүүн	Багш	Ерөнхий хими
25	Б.Ганхуяг	Багш	Биеийн тамир
26	А.Ариунболд	Багш	Ерөнхий физик
27	Х.Төмөрбаатар	Багш	Монголын түүх соёл, ёс заншил
28	Б.Эрдэнэбаяр	Лаборант	

29	Ч.Цогтбаяр	Лаборант	
30	Б.Хонгорзул	Оюутан хариуцсан багш	
31	Ч.Батхишиг	Ахлах нягтлан	
32	Г.Отгонжаргал	Номын санч	
33	П.Оюунзул	СНА-ны мэргэжилтэн	

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс, түвшин	Сонгосон байдал
1	Н.Оюунбаатар	1-р курс	Бүлгийн дарга
2	Б.Төрбаяр	1-р курс	Оюутны байрны төлөөлөл
3	Б.Төгөлдөрбуд	1-р курс	Оюутан үйлчилгээний төв
4	Ч.Халиунаа	1-р курс	Оюутан үйлчилгээний төв
5	М.Бөхчулуун	1-р курс	Бүлгийн дарга
6	Э.Цэлмэг	2-р курс	Хөдөө орон нутгийн оюутан
7	Т.Наурызбек	2-р курс	Хөдөө орон нутгийн оюутан
8	Х.Дүгэрсэд	3-р курс	Бүлгийн дарга
9	Э.Ариунболд	3-р курс	Бүлгийн дарга
10	Т.Энхбат	3-р курс	Сайн дурын оюутан
11	Г.Галбадрах	3-р курс	Хөдөлмөр эрхэлдэг оюутан
12	Б.Дашчирэв	3-р курс	Төрийн сан
13	А.Номин	4-р курс	Оюутны байрны төлөөлөл
14	П.Төгөлдөр	4-р курс	Хөдөлмөр эрхэлдэг оюутан
15	Э.Зулцэцэг	4-р курс	Бүлгийн дарга
16	Б.Эрдэнэбүүвэй	4-р курс	Орон нутгийн оюутан
17	Б.Энх	4-р курс	Тэтгэлэгт оюутан
18	У.Нямбаяр	4-р курс	Тэтгэлэгт оюутан
19	Х.Сүхбат	4-р курс	Оюутны байрны оюутан

III. Ажил олгогчдын нэрс

№	Ажил олгогчийн нэр	Байгууллага, албан тушаал
1	Н.Эрдэнэбаатар	“Хос билигт наран” ХХК Ерөнхий захирал
2	Ц.Баярмаа	“Долгион-Од” ХХК Ерөнхий захирал
3	П.Норжиндулам	“Гранд дрийм” констракшн Ерөнхий захирал
4	Т.Эрдэнэбулган	“Мета менежмент” ХХК Ерөнхий захирал
5	Г.Цэнддорж	“Мөнх Гаруда” констракшн Ерөнхий захирал
6	О.Дуламсүрэн	“Мон хутагт” Ерөнхий менежер
7	Н.Дашдорж	“IG CON” LLC Ерөнхий менежер
8	Б.Мөнхнасан	“АЙ ЭМ АЙ” ХХК Ерөнхий менежер

IV. Төгсөгчдийн нэрс

№	Төгсөгчийн нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал
1	Мөнх	2018	Templand
2	Буяннэмэх	2018	Их бодь

3	Гомбодоо	2018	Эм Эс Эл
4	Өнөболд	2019	Мөнх Гаруда
5	Гэрэлмаа	2019	Мандуул бэхи
6	Гэрэлсүх	2019	Батлан хамгаалах яамны барилга захиалагчийн алба
7	Б.Мөнх-Эрдэнэ	2019	DHBU
8	Янжинлхам	2020	Бат холбоос цамхаг
9	Э.Гантогтох	2020	TET building
10	Чогдон	2020	Фин сервис
11	Пүрэвдорж	2020	СТӨҮНХИЖ ХХК
12	Цолмонбаатар	2020	“Базура” ХХК
13	Намуундарь	2021	Мета менежмент
14	Тэмүүжин	2021	Мон хутагт
15	Бат-Оргил	2021	Мөнх Гаруда
16	Энхбаяр	2021	Рapid-Архитектур
17	Отгонцэцэг	2021	Сод дүүрэн хүч

Хавсралт 1. Барилгын инженер бакалаврын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн

Хавсралт 2. Барилгын инженер бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө